



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 09 сарын 18 өдөр

Дугаар A/256

Чойр

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, 29.2, 33 дугаар зүйлийн 33.2, Засгийн газрын 2016 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг хавсралт ёсоор шинэчлэн тогтоосугай.

2. Шинээр байгуулагдсан бүтцийн хүрээнд албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулан, хэлтсийн дарга нар болон албан хаагчдыг томилон ажиллуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Содном/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” A/256 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ

